



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 06 өдөр


Дугаар A/43

Улаанбаатар хот

Г Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг зохион байгуулах 3 шатны журмыг шинэчлэн батлуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, "Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.12. дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зам, тээврийн хөгжлийн төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг зохион байгуулах 3 шатны журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг нийт ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн /Б.Мөнхбаяр/, Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Б.Батсайхан/-т тус тус үүрэг болгосугай.
3. Уг тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн A/113 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Зам, тээврийн хөгжлийн төвийн Захирлын
2022 оны 07 дугаар сарын 06 -ны өдрийн
A/ дугаар тушаалтын хавсралт
73

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗШАТНЫ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, "MNS ISO 45001:2018" Зам тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн тогтолцоо, "ЗБНБД 15-002-2016" Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм, "Зам тээврийн хөгжлийн төвд мөрдөх "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам"-ыг үндэслэн боловсруулсан болно.
- 1.2. Энэхүү журам нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (цаашид ХАБЭА гэнэ)-н хяналтын төрөл, зохион байгуулалт, агуулгыг тодорхойлох бөгөөд төвийн бүх хэлтэс нэгжид хамаарна.
- 1.3. ХАБЭА-ын хяналтын гол зорилго нь ХАБЭА-н хууль тогтоомж, техникийн норм, дүрэм, журам, зааврын шаардлага ХАБЭА-н талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүн болон авч буй арга хэмжээ нь Бодлогын хэрэгжилтийг хангасан үр ашигтай байдал ажлын байрны болон ажил гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангаж буй эсэхийг шалгах, тодорхойлох зорилготой үзлэг шалгалтын үйл явц юм. Төвийн хэмжээнд ХАБЭА-н хяналтыг Захирал, хэлтсийн дарга, төлбөр авах цэгийн ахлагч, ахлах мэргэжилтэн, техникийн ашиглалтын багийн ахлагч, аливаа багийг ахалсан инженер техникийн ажилтнууд зэрэг удирдах албан тушаалтууд хэрэгжүүлнэ.
- 1.4. ХАБЭА-н хяналтад урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр үйлдвэрчний эвлэлийн тэргүүлэгчид оролцож болно.
- 1.5. ХАБЭА нь төвийн үйлдвэрлэлийн орчин, ажлын байрны нөхцөл, барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмж, дараалтат сав, шугам хоолой, химийн хорт, аюултай, тэсрэх дэлбэрэх бодис, галын аюулгүй байдал, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, лабораторийн болон хээрийн хэмжилтийн багаж тоног төхөөрөмж тэдгээрт тавигдах шаардлагыг хэрхэн ханганд ажиллаж байгааг шалган, зөрчил дутагдлыг цаг тухайд нь илрүүлэн арилгаж байх зорилгоор турван шатны хяналтын ажлыг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөгө болгоно.
- 1.6. Гурван шатны хяналтыг тогтоосон хугацаанд нь тогтмол явуулж байх нь байгууллагын захиргаа, албан тушаалтан нараас ХАБЭА-г хангах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх ажлын үндсэн арга хэлбэр юм.
- 1.7. ХАБЭА-н Гурван шатны хяналтыг хамтад нь явуулахыг хориглоно.
- 1.8. ХАБЭА-н хяналт нь дараах гурван шатны хяналтаас бүрдэнэ. Үүнд:
 - I-р шатны хяналтыг ажилтан эсхүл ажил шууд удирдаж буй ажилтан
 - II-р шатны хяналтыг ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн гишүүд
 - III-р шатны хяналтыг Байгууллагын даргын тушаалаар томилогдсон комисс

ХОЁР. ХАБЭА-н НЭГДҮГЭЭР ШАТНЫ ХЯНАЛТ

- 2.1. Ажил гүйцэтгэж байгаа ажилтан эсхүл ажил шууд удирдаж буй ажилтан тус тусын хариуцсан ажлын байранд ажлын эхлэл ба ажлын явцын туршид аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөлийн байдалд ажил эхлэх бүрт хийх шалгалтыг **анхан шатны хяналт** гэнэ.

2.2. Анхан буюу I дүгээр шатны хяналтыг тухайн хэлтсийн дарга, ТАЦ-ын ахлагч, ахлах шинжээч инженер /мэргэжилтэн/ нар нь тухайн нөхцлийг хянана.

2.3. Ажилтан ажил эхлэхийн өмнө 15 минутаас багагүй хугацаагаар ажлын байрандаа эрсдэлийн хяналтын үзлэг хийж "ХАБЭА-н З шатны хяналт"-ын 1-р шатанд бичилт хийн илэрсэн зөрчлийг арилгах эсхүл удирдах албан тушаалтанд мэдэгдэх зэрэг тодорхой арга арга хэмжээ авсны дараа ажлаа эхлүүлнэ.

2.4. I дүгээр шатны хяналтыг өдөр тутамд ажил гүйцэтгэх эхлэх явцад тогтмол хийнэ.

2.5. Нэгдүгээр шатны шалгалтаар дараах зүйлийг шалгана. Үүнд:

а/ Урьд өмнө хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан байдал;

б/ Ажлын байран дахь багаж хэрэгсэл, сэлбэг хэрэгслийн эмх цэгц;

в/ Машин тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал;

г/ Ажлын тусгай хувцас, гутал, хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн өмсөж хэвшсэн байдал;

д/ Машин тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсгийн хаалт, хамгаалалт, аюултай бүс, орчинд байх хориглосон тэмдгийн бүрэн бүтэн байдал;

е/ Дохиоллын системийн болон гал эсэргүүцэх багаж хэрэгслийн ажиллагааны найдвартай, бүрэн бүтэн байдал;

ё/Ажлын тусгай хувцас, аврах, хамгаалах хэрэгслийн бэлэн байдал;

ж/ Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэгтэй холбоотой аюулгүй ажиллагааны зааварчилгааны дүрэм, журам сахиж байгаа байдал;

2.6. Албан тушаалтан /ажилтан/ илэрсэн зөрчил дутагдлыг "ХАБЭА-н гурван шатны хяналтын дэвтэр"-ийн 1 дүгээр шатны хяналт гэсэн хэсэгт хүснэгтийн дагуу бичиж ажил удирдагчийн хяналтан дор зөрчлийг арилгах арга хэмжээ авна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг төвийн бүх салбар нэгжийн хүчээр арилгах боломжгүй бол дээд шатны албан тушаалтан захиргааны хэлтсийн дарга, захиралд нэн даруй мэдээлнэ. Салбар нэгж, хэлтэс, албад уг зөрчлийг захиргааны хэлтсийн дарга удирдагчтай хамтран илэрсэн зөрчлийг арилгах хугацааг тодорхойлж "ХАБЭА-н гурван шатны хяналтын дэвтэр"-т бичилт хийнэ.

2.7. I дүгээр шатны хяналтын явцад илэрсэн ХАБЭА-н зөрчил дутагдлыг нэн даруй арилгана.

2.8. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж чадах боломжгүй тохиолдолд ажлыг зогсоож ХАБЭА-н зөрчлийн талаар дээд шатны удирдлагад нэн даруй мэдэгдэж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах үүрэгтэй.

2.9. ХАБЭА-н шаардлагыг биелүүлээгүй ажилтан албан хаагч, I дүгээр шатны хяналтыг явуулаагүй салбар нэгжийн удирдах албан тушаалтан зөрчигчдөд байгууллагын дотоод журам, Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу зохих хариуцлагыг оногдуулна.

ГУРАВ. ХАБЭА-Н ХОЁРДУГААР ШАТНЫ ХЯНАЛТ

3.1. Байгууллагын ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн гишүүд зөвлөлийн даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу ХАБЭА-н чиглэлээр хийх нарийвчилсан шалгалтыг **хоёр дахь шатны хяналт** гэнэ.

3.2. II дугаар шатны хяналтыг байгууллагын ХАБЭА-н хариуцсан мэргэжилтэн бие даан эсвэл хэлтсийн дарга, төлбөр авах цэгийн ахлагч, ахлах мэргэжилтэн, техник ашиглалтын багийн ахлагч, аль нэг баг ахласан инженер техникийн ажилтантай хамт өмнө өгсөн зааварчилгааны агуулгаар давтаж өгнө.

3.3. II дугаар шатны хяналтын давтан зааварчилгааг сард 1 удаа хийнэ.

3.4. II дугаар шатны хяналтын явцад ажил мэргэжлийн онцлогоос нь хамааруулан ХАБЭА-н дүрмийг ЗЗБН6Д15-002-2016-ийн аюулгүй ажиллагааны шаардлага тус бүрээр ажлын байрны жагсаалтанд орсон бүх ажлын байруудын нөхцөл байдал нь ХАБЭА-н шаардлагад нийцэж буй эсэх талаар хяналт тавьж ажиллана.

3.5. Хоёрдугаар шатны шалгалтаар дараах зүйлийг шалгана. Үүнд:

а/ Энэхүү журмын 1.8-д заасан нэг ба хоёр дахь шатны хяналтыг чанартай хийсэн эсэх, урьд өмнө илэрсэн зөрчлийг арилгасан байдал, "ХАБЭА-н З шатны хяналтын дэвтэр"-ийн хөтлөлтийн чанар;

б/ ХАБЭА-н талаар мөрдөгдөж буй тушаал заавар, журам, албан шаардлага, сээрэмжлүүлэг, удирдах ажилтнаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт;

в/ Барилга байшин, техник, тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгсэл, даралтат сав, цахилгааны эх үүсгэвэр, өргөх, зөөх, тээвэрлэх механизм стандарт, дүрмийн шаардлагыг хангаж байгаа, тэдгээр нь гэмтэлгүй хэвийн ажиллаж байгаа эсэх, төлөвлөгөөт засвар үйлчилгээг хийсэн байдал;

г/ Тэсэрч дэлбэрэх аюул, хордлого, гол түймэр, шаталт гарах нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй эсэхийг хянаж магадлах арга ажиллагаа, хянах, дохиолох, сэргийлэх хэрэгсэл системүүдийн бүрэн бүтэн, найдвартай байдал;

д/ Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байгаа байдал, ажлын байранд аюулгүй ажиллагааны үнэлгээ хийсэн байдал;

е/ Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, дохио, санамж, гар багажны бүрэн бүтэн байдал, зөв ашиглаж байгаа эсэх, тэдгээр нь стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх;

ё/ Ажлын байруудын эмх цэгц, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал, гэрэлтүүлэг, агааржуулалт, галын аюулгүйн хамгаалах, хянах, хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдал, баталгаажуулалт;

ж/ Аюултай газрыг хааж, хамгаалж аюулгүйн тэмдэглэгээ тавьсан байдал;

з/ Ажилтны ажил, амралтын дэглэмийн хэрэгжилт, сахилга хариуцлагын байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой бусад асуудлууд;

к/ Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаарх мэдлэгийг түүвэрчлэн шалгах;

3.6. II дугаар шатны хяналтын явцад илэрсэн ХАБЭА-н шаардлагын зөрчлийг нэн даруй арилгана. Шаардлагатай тохиолдолд илэрсэн зөрчлийг Удирдлагад танилцуулж зөрчлийг арилгах хугацаа, хариуцагчийг томилон арилгуулах.

3.7. Ажилтнуудын эрүүл мэнд, амь насанд нь аюултай ажлын байр, тээврийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж дээр ажиллах эсвэл осол зөрчил хүргэж болзошгүй зөрчил илэрсэн тохиолдолд уг зөрчлийг бүрэн арилгах хүртэл ажлыг түр зогсоноо.

3.8. Хэлтсийн дарга нар илэрсэн зөрчил дутагдлыг захирлын зөвлөлийн хурал дээр II дугаар шатны хяналтын явцад илэрсэн зөрчлийг танилцуулж гарсан шийдвэрийн талаар хамт олонд мэдээлэл хийж, холбогдох удирдах ажилтнуудад тэдгээрийг арилгах талаар даалгавар өгч, зөрчигчдөд, Хөдөлмөрийн тухай хууль, Төвийн дотоод журмын дагуу сахилгын хариуцлагыг оногдуулна.

3.9. II дугаар шатны хяналтын үр дүнг "ХАБЭА-н II шатны хяналтын урьдчилан сэргийлэх ажлын дэвтэр"-т илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ, арилгах хугацаа, хариуцагчийг тодорхой бичилт хийх ба хяналтаар ажилласан хүн хариуцагч нарын гарын үсгийг зурж

баталгаажуулна.

3.10. Хүний амь нас эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд ажлыг зогсоож, аюултай бүсээс ажилтныг гаргаж зөрчлийг арилгах арга хэмжээг яаралтай авна.

ДӨРӨВ. ХАБЭА-Н ГУРАВДУГААР ШАТНЫ ХЯНАЛТ

4.1. Байгууллага дээр мөрдөгдөж буй тушаал, шийдвэрийн дагуу байгууллагын ХАБЭА-н орон тооны бус зөвлөл, байгууллагын Хяналт шинжилгээ, дотоод аудитын ажилтан нарыг оролцуулсан комиссыг даргын тушаалаар томилон байгууллагын хэмжээнд ХАБЭА-н ажилд сар, улиралд хийх шалгалтыг **гурав дахь шатны хяналт** гэнэ.

4.2. III дугаар шатны хяналтыг байгууллагын удирдлагууд эсвэл захирлын баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн явуулах ба ажлын хэсгийн ахлагч нь захирал эсвэл захиргааны дарга үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл ХАБЭА хариуцсан мэргэжилтэн нар, тэдгээрийн орлогчид, ахлах мэргэжилтнүүд зэргээс бүрдсэн комисс гарган ажиллана.

4.3. III дугаар шатны хяналтыг улиралд 1 удаа хийнэ. Монгол орны нутаг дэвсгэрт байрласан алслагдсан цэгүүдэд III дугаар шатны хяналтыг улиралд 1 удаа хийнэ.

4.4. III дугаар шатны хяналтын явцад дараахь зүйлийг шалгана.

а/ I, II дугаар шатны хяналтыг чанартай хийсэн эсэх,

б/ I, II дугаар шатны хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгасан эсэх авсан арга хэмжээтэй танилцах

в/ Ажлын байруудын нөхцөл байдал нь ХАБЭА-н шаардлагад нийцэж буй эсэх;

г/ ХАБЭА-н чиглэлээр гарсан дүрэм, журам,

заавар, тушаалын мөрдөлт түүний хэрэгжилт

д/ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, явуулсан эсэх,

е/ Ажилтнуудыг эрүүл мэндийг үзлэгт хамруулсан эсэх

ё/ Ажилтнуудад зааварчилгаа өгөх ажлын хэрэгжилт, чанар, ажилтнуудын ур чадвар, мэдлэг, ХАБЭА-н зөв дадал соёлд суралцсан байдал;

ж/ Ажлын хувцас тусгай хамгаалах хэрэгслийн хангалт, ашиглалт, чанар, ажлын

хувцсыг угааж ариутгаж өмсөж хэвшсэн байдал;

з/ Ажилтнуудын ажил үүргийн хуваарилалт, цаг ашиглалт, ажил амралтын дэглэмийг сахисан байдал;

и/ Ажлын байрны тохижилт, тав тухтай байдал, гэрэлтүүлэг, агааржуулалт сөрөг нөлөөлөл үүссэн эсэх;

к/ Үйлдвэрлэлийн осол хурц хордлого эрүүл мэндийг судлан бүртгэх зөвлөл, комиссын ажлын явц үйл ажиллагаанд хяналт хийх;

л/ Ажлын байрны гадна орчины аюулгүй байдалд /ТАЦ/

4.5. III дугаар шатны хяналтын үр дүнг ахлагч нь ажлын хэсгийн гишүүдийн хамт шалгагдсан бүх салбар нэгж, хэлтсийн удирдах ажилтнуудыг байлцуулан дүнгийн хурал хийнэ. Дүнгийн хурал дээр ажлын хэсгийн гишүүн бүр илэрсэн зөрчил, дутагдлын талаар мэдээлж, ХАБЭА-н нөхцөл байдалд үнэлгээ ("сайн", "хангалттай", "хангалтгүй") өгнө. Комиссын гишүүдийн өгсөн үнэлгээний үндсэн дээр ажлын хэсгийн ахлагч байгууллагын дарга ХАБЭА-н нөхцөл байдалд ерөнхий үнэлгээ өгнө.

4.6. III дугаар шатны хяналтын үр дүнг "ХАБЭА-н III шатны хяналтын урьдчилан сэргийлэх ажлын дэвтэр"-т тэмдэглэн илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ, арилгах хугацаа, салбар нэгж, хэлтсийн дарга нарыг тодорхой бичиж зааж өгөх ба комиссын удирдагч, гишүүдийн болон салбар нэгж, хэлтэс, албадын дарга нарын гарын үсгийг зурж баталгаажуулна. Албан шаардлага хүргүүлсэн тохиолдолд хоёр хувь үйлдэх бөгөөд нэг хувийг тухайн салбар нэгж, хэлтэс, албадын даргад хүлээлгэн өгнө.

4.7. III дугаар шатны хяналтын албан шаардлагын боловсруулалт, бүртгэлийг төвийн ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцна.

4.8. III дугаар шатны хяналтын явцад илэрсэн ХАБЭА-н шаардлагын зөрчил дутагдлыг арилгаж буй байдалд комиссын гишүүд, ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн хяналт тавина.

...ооо...